



Манай оронд суурин үрждэг махчин шувууд Эрдэнэсантын уулсаар харьцангуй элбэг бөгөөд үүрлэж өндөглөдөг 9 зүйлийн түгээмэл махчин шувууд байдаг. Үүнд ооч ёл, цармын бүргэд, нөмрөг тас, идлэг шонхор, сохор элээ, шилийн сар, хээрийн бүргэд, начин шонхор, эгэл шаршувуу орно. Нөмрөг тасын хувьд үржлийн томоохон популяци байдаг ба нийтдээ 40 гаруй үүр тогтмол судалгаанд хамрагддаг байна.

Г.Амархүү, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв

Хиймэл үүрэнд бойжсон идлэг шонхорын *Falco cherrug* ангаахай бүрийг өнгөт бөгжөөр тэмдэглэнэ

Монголын Байгаль орчин аялал жуулчлалын яам (хуучнаар) болон Абу Дабигийн Байгаль орчны хөгжлийн агентлаг хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжиж буй хиймэл үүрэнд түшиглэсэн идлэг шонхорын хамгааллын менежментийн хөтөлбөрийн хүрээнд зүүн бүсийн 5 аймгийн 20 сумын нутагт 5000 хиймэл үүр байрлуулаад байгаа билээ. Эдгээр хиймэл үүрэнд үүрлэж байгаа идлэг шонхорын хосуудын тоо жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2014 онд 2500 ангаахайн амжилттай бойжин ниссэн.

Идлэг шонхорын судалгаанд 2013 оноос ангаахайн нүүдэл шилжилт, мэнд үлдэлтийг судлах зорилгоор өнгөт бөгжийг ашиглаж эхэлсэн. Өнгөт бөгж нь шувуундаа ямар нэгэн сөрөг нөлөөгүй, хөлийг нь барьж боохгүй төдийгүй алсаас харагдац сайтай зэрэг давуу талтай. Өнгөт бөгж нь хуванцар материалаар хийгдсэн бөгөөд харьцангуй уян хатан, өөр дээрээ 1 үсэг, 0-99 гэсэн ахин давтагдахгүй дугаартай, холбоо барих хаягтай. Өндөгнөөс хагарсан ангаахайг ойролцоогоор 3-4 долоо хоногийн настай байхад нь бөгжлөх бөгөөд энэ үед ангаахай үүрнээсээ амжилттай нисэх эх суурь нь бүрэн тавигдсан байдаг гэж судлаачид үздэг. Өнгөт бөгж зүүснээр хиймэл үүрэнд бойжиж байгаа шонхорын үхэл хорогдол, үржлийн дараах шилжилт хөдөлгөөний тухай нарийвчилсан мэдээ цуглуулах боломжтой болох юм. Хэрэв энэхүү бөгжтэй шувуудыг хаа нэгтээ олж харсан, үхсэн байдалтайгаар олсон тохиолдолд та бүхэн бөгж дээрх холбогдох хаягаар бидэнд мэдэгдэнэ үү.

Идлэг шонхорын хиймэл үүрэнд 2013 онд нийт 548 хос идлэг шонхор үүрлэсэн бөгөөд 2000 ангаахайг цагаан дэвсгэртэй бөгжөөр бөгжилсөн бол 2014 онд нийт 720 хос идлэг шонхор хиймэл үүрэнд үүрлэж



2500 гаруй ангаахайг ногоон дэвсгэртэй бөгжөөр бөгжилөв. Сүүлийн 2 жилд нийт 4500 ангаахай бөгжилснөөс 110 бөгжний тухай мэдээлэл эргэн мэдэгдсэн ба хамгийн хол зайд нүүдэллэсэн ангаахай 1000 гаруй километр зайд шилжилт хийсэн байна. Харамсалтай нь тэдгээр 110 бөгжний мэдээллийн 90%-д нь бөгжтэй ангаахай үхсэн байдалтайгаар, тэр тусмаа бараг бүгд цахилгаан түгээх 15 кв-ын шугамд хүчдэлд цохиулж эндсэн байна.

Б.Батмөнх, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв

Хиймэл үүрэнд Эгэл шаршувуу *Bubo bubo* анх удаа амжилттай үүрлэв

Монголын зэрлэг амьтан судлах хамгаалах төв, Английн Олон улсын зэрлэг амьтны зөвлөх компанийн хамтран хэрэгжүүлж байгаа Монгол орны идлэг шонхорын судалгаа, хамгаалал төслийн хүрээнд 2006 оноос хойш байгалийн болон хиймэл үүрэнд үүрлэсэн идлэг шонхорын үржлийн популяцид мониторинг хийж байгаа билээ. Төслийн үр дүнгээс харахад хиймэл үүр байгуулснаар идлэг шонхорын үржлийн популяцийг дэмжээд зогсохгүй үржлийн бүтээмж өндөр байгаа үр дүн гарсан. Мөн эдгээр хиймэл үүрэнд манай орны хээрийн бүсэд түгээмэл тохиолддог 4 зүйлийн шувууд идлэг шонхор (*Falco cherrug*), начин шонхор (*Falco tinnunculus*), шилийн сар (*Buteo hemilasius*), хон хэрээ (*Corvus corax*) тогтвортой үүрлэж, үүрлэх хосын тоо жилээс жилд нэмэгдсээр байна. Эдгээрээс гадна зарим ховор тохиолдолд өөр бусад шувуу үүрлэж байна.

2007 онд Дархан суманд байрлах туршилтын үүрний нэгэнд нь цармын бүргэд (*Aquila chrysaetos*) үүрлэсэн. Харамсалтай нь энэ хосын үржил өндөг дарах үедээ эндэж амжилтгүй болсон. Бүргэд үүрлэсэн тухайн үүрний дээд хэсэг нь задгай бөгөөд өндөр ханатай байсан нь нөмөр нөөлөг нөхцлийг бүрдүүлж бүргэд үүрлэх шалтгаан болсон болов уу. Үүрлэлт амжилтгүй болсон нь үүрний хэмжээ бага өөрөөр хэлбэл өндөгөө хангалттай сайн дарах болон дулаан байлгах нөхцлийг бүрдүүлж чадаагүйтэй холбоотой байх боломжтой.

2014 онд Сүхбаатар аймгийн Халзан сумын нутагт байрлах AN3430 дугаартай хиймэл үүрэнд шар шувуу үүрлэж байхыг бүртгэв. Анх энэ үүрийг 4 сарын 10-нд шалгахад 3 өндөг



байсан. Харин үржлийн хугацаанд 1 өндөг эндэж, 2 ангаахай амжилттай бойжиж 6 сарын дундуур үүрнээсээ ниссэн. Байгаль дээр эгэл шаршувуу хадны хонгил, хавцлын завсар гэх мэт нөмөр нөөлөг орчныг илүүтэйгээр шүтэж үүрлэдэг. Харин шаршувуу төмөр хийцийн хиймэл үүрийг сонгон амжилттай үржсэн нь тун сонирхолтой баримт бөгөөд хиймэл үүрний хэрэглээ бидний тооцоолж байснаас илүү олон зүйлд өгөөжтэй байж болохыг харуулж байна.

Б.Батбаяр, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв